



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/16

Улаанбаатар хот

**Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.6, 33.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах заалт, Нийслэлийн Онцгой комиссын даргын 2018 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэх тухай” 01 дугаар тушаал, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны А/17 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг сар шинийн баярын амралтын хугацаанд буюу 2018 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагаас 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 10.00 цаг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг гамшгаас хамгаалах албаны штабын дарга /Т.Гэрэлсүрэн/-д үүрэг болгосугай:

2.1 Албаны бүрэлдэхүүний зарлан мэдээллийн бэлэн байдлыг хангаж, холбогдох утсыг нээлттэй байлган, хотоос гарах тохиолдолд орлох албан тушаалтныг томилох.

2.2 Байгууллагын бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, үүсэж болзошгүй аюул ослоос сэргийлэх, гал түймрийн аюулгүй байдлыг хангах.

2.3 Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун туслах материалын нөөцийг бүрдүүлэх.

2.4 Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, үүрэг гүйцэтгэсэн тухай дүн, илтгэх хуудсыг 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 11.00 цагт Нийслэлийн Эрүүл мэндийн албанд хүргүүлэх.

3. Болзошгүй гамшгийн үед шаардлагтай арга хэмжээг авч, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 320981 дугаарын утсанд шуурхай дамжуулж, дүнг дурдсан хугацаанд хожимдолгүй хүргүүлэхийг штабын дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг чанарын албаны дарга /Э.Оюумаа/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БОДЬЦЭЦЭГ

170 70 0128

